

Үнэ шилжилтийн хяналт шалгалт ба бэлэн байдал

Танай компани татварын хяналт шалгалтад бэлэн үү? Татварын давхардал, алданги/торгуулийн эрсдэл байгаа юу?

Энэхүү мэдээлэлд татварын хяналт шалгалт ба үнэ шилжилтийн иж бүрэн баримтжуулалтын ач холбогдлыг авч үзсэн болно.

Холбогдох хаяг:

Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Марина Тарнавская

Ахлах Менежер, Үнэ шилжилтийн үйлчилгээ хариуцсан удирдагч
tarnavska.maryna@pwc.com

Лхачингийн Аззаяа

Менежер, Үнэ шилжилтийн үйлчилгээ
azzaya.lkhachin@pwc.com

ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас: + 976 70009089
Факс: +976 11 322068

www.pwc.com/mn

Үнэ шилжилтийн хяналт шалгалт

Үнэ шилжилт (“ҮШ”) нь бизнесийн үйл ажиллагаа, зардал, татварын байр суурьт нөлөөлөх гол асуудлуудын нэг болоод байна. ҮШ-ийн оновчгүй бодлого нь татварын давхардал үүсгэхээс гадна их хэмжээний торгууль, хүү төлөхөд хүргэнэ.

Монгол улсын Татварын албаны анхны ҮШ-ийн хяналт шалгалт

Монгол улсын татварын алба (“МТА”) анхны ҮШ-ийн хяналт шалгалтаар 649 тэрбум (ойролцоогоор 228 сая ам. доллар) татварын акт ногдуулсныг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (“ЭЗХАХБ”) -аас зарласан. МТА (<http://www.mta.mn/c/view/80034>) болон ЭЗХАХБ-ын (<https://www.oecd.org/tax/mongolian-tax-administration-partners-with-international-organisations-and-issues-first-transfer-pricing-tax-assessment-for-usd-228-million.htm>) цахим хуудаст мэдээлснээр, энэхүү татварын хяналт шалгалт нь ЭЗХАХБ, “Засгийн газар хоорондын уул уурхай, үнэт металл, тогтвортой хөгжлийн форум”, ЭЗХАХБ болон Нэгдсэн үндэсний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Хил хязгааргүй татварын байцаагч хөтөлбөр” зэрэг урт хугацааны техникийн туслалцааны төслүүдийн үр дүн гэж онцолжээ.

Энэхүү татварын хяналт шалгалтын үр дүн нь маргааны түвшинд байгаа гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа ч, ЭЗХАХБ үүнийг уул уурхайн салбарт татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхтэй тэмцэх, татварын дүрмийг олон улсын шилдэг туршлагатай уялдуулахад чухал ач холбогдолтой гэж үзжээ.

ҮШ-ийн хяналт шалгалтын зохицуулалт

Монголын татварын албанаас 2021 оны 4-р сарын 15-ны өдөр “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулсан. Шинэчилсэн журамд татварын хяналт шалгалтыг энгийн, хялбаршуулсан, нарийн төвөгтэй гэж ангилсан. Энгийн/ хялбаршуулсан хяналт шалгалтыг татварын болзошгүй эрсдэлийн үед нарийн төвөгтэй хяналт шалгалт болгон өөрчлүүлэх боломжтой “Нарийн төвөгтэй” татварын хяналт шалгалтыг татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм, үнэ шилжилтийн журмыг хэрэгжүүлэх тохиолдолд гүйцэтгэнэ. Хэрэв татвар төлөгчийн харилцан хамааралтай бүхий талуудтайгаа хийсэн ажил гүйлгээний үнэ нь бие даасан этгээдүүдийн ажил гүйлгээний үнээс ялгаатай байвал татварын алба ҮШ-ийн хууль тогтоомжийн дагуу үндсэн болон хоёрдогч ҮШ-ийн тохируулгуудыг хийх эрхтэй. ҮШ-ийн хяналт шалгалтыг гүйцэтгэх хугацааг хуульд нарийн заагаагүй ба энгийн/ хялбаршуулсан хяналт шалгалтаас илүү урт хугацаа шаардагдаж болно.

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2021 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

ҮШ-ийн тохируулгууд

Хэрэв татвар төлөгч нь ҮШ-ийн тайлан гаргаагүй, эсхүл харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээгээр татварын суурийг бууруулсан бол татварын алба ҮШ-ийн үндсэн тохируулгыг хийж татварыг нөхөн ногдуулна. Аж ахуйн нэгжийн орлогын татвар болон хувь хүний орлогын татварын зорилгоор үндсэн тохируулгын үр дүнд үүссэн зөрүүг ногдол ашиг гэж үзэн татвар ногдуулах бөгөөд үүнийг хоёрдогч тохируулга гэнэ. ҮШ-ийн тохируулгын үед хуульд заасан татварын хариуцлага, торгууль ногдуулна.

Хэрэв татвар төлөгч нь харьцуулалтын тохируулга хийсэн бол уг тохируулгыг мэдээллийн эх үүсвэр болон холбогдох бусад баримтаар нотлох шаардлагатай. Татварын алба нь олон улсын татварын гэрээний дагуу харилцан тохиролцоо журмыг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд татварын суурийг бууруулах аливаа тохируулгыг хийхгүй.

Харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын түгээмэл ажил гүйлгээнүүд ба ҮШ-ийн асуудлууд

ҮШ-ийн хяналт шалгалтын явцад харилцан хамааралтай талуудын хооронд түгээмэл хийгддэг зээлийн санхүүжилт, эрхийн шимтгэл, менежментийн үйлчилгээний төлбөр, дундын үйлчилгээний зардлын хуваарилалт зэрэг ажил гүйлгээнүүдийг нарийвчлан шалгаж болно.

Иймд, татвар төлөгч нь харилцан хамааралтай талуудын хоорондын ажил гүйлгээг “сунгасан гарын зарчим”-ын дагуу хийгдсэнийг нотлох гэрээ, зардал хуваарилах бодлого, бусад баримтуудыг тайлангийн хамт бэлэн байлгах шаардлагатай.

ҮШ-ийн баримтжуулалтын иж бүрэн байдал

2020 оноос эхлэн холбогдох татвар төлөгчид Ерөнхий ҮШ-ийн тайлан, Дотоод ҮШ-ийн тайлан, Улс бүрээр ҮШ-ийн тайлан, ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлангуудыг бэлтгэн тайлагнах болсон. Татвар төлөгчийн ҮШ-ийн баримтжуулалтад үндэслэн ҮШ-ийн хяналт шалгалтад хамруулах нь олон улсад түгээмэл байдаг. Иймд иж бүрэн ҮШ-ийн баримтжуулалт/тайлан нь татвар төлөгчийг ҮШ-ийн хяналт шалгалтын эрсдэлээс хамгаалах боломжтой юм. Иймд, иж бүрэн ҮШ-ийн баримтжуулалт/тайлан нь татварын маргаанаас зайлсхийх, татварын байр сууриа хамгаалах зардал, цаг хугацааг хэмнэх боломжийг олгоно.

2020 оноос хэрэгжиж эхэлсэн ҮШ-ийн хууль тогтоомж

Татвар төлөгчид 2020 оноос хэрэгжиж эхэлсэн дараах ҮШ-ийн хууль тогтоомжийг дагаж мөрдөж байна. Үүнд:

- 2019 оны 3-р сарын 22-ний өдөр батлагдсан Монгол улсын Татварын ерөнхий хууль: <https://www.legalinfo.mn/law/details/14403?lawid=14403>
- 2019 оны 3-р сарын 22-ний өдөр батлагдсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль: <https://www.legalinfo.mn/law/details/14407?lawid=14407>
- Сангийн сайдын 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн 308 дугаар тушаалаар баталсан “ҮШ-ийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”: <https://www.legalinfo.mn/annex/details/10548?lawid=15010>
- Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 9-р сарын 3-ны өдрийн А/133 дугаар тушаалаар баталсан “Тайлангийн маягт, хавсралт мэдээ, нөхөх заавар”: <https://www.legalinfo.mn/annex/?lawid=15641>

Танд PwC хэрхэн туслах вэ

Тайлагнал, хууль даган мөрдөх:

- Бүх төрлийн ажил гүйлгээний ҮШ-ийн баримтжуулалт, тайланг дотоодын хууль тогтоомжийн шаардлагын дагуу бэлтгэх, өөрчлөлт оруулах
- Үнэ, ашиг, хүү, эрхийн шимтгэлийн түвшинд жишиг үнийн судалгаа хийх
- ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан, Дотоод ҮШ-ийн тайлан, Ерөнхий ҮШ-ийн тайлан болон Улс бүрээр ҮШ-ийн тайлан бэлтгэх, тусалцаа үзүүлэх

Өдөр тутам тусалцаа үзүүлэх:

- ҮШ-ийн эрсдлийг тодорхойлох
- ҮШ-ийн бодлого, журам боловсруулах, байгууллагын үнэ шилжилтийн асуудал хариуцсан ажилтанг сургах
- ҮШ-ийн асуудлаар шуурхай зөвлөгөө өгөх

Төлөвлөлт ба өөрчлөлт:

- Бизнесийн үйл ажиллагааны бүтцийг татварын үр ашигтай байдалд нийцүүлэх
- Үнэ шилжилтийн бодлогыг бизнесийн загвартай уялдуулах
- Төлөөний газрын ашиг, орлогыг зохистой хуваарилах

Байр сууриа хамгаалах ба маргаан шийдвэрлэх:

- Стратеги, аргумент боловсруулах
- Татварын хяналт шалгалтын үед тусалцаа үзүүлэх
- Татварын маргааны үед тусалцаа үзүүлэх
- Харилцан тохирох журмын хүрээнд тусалцаа үзүүлэх